

# 1

## ШИЛЖИЛТИЙН ҮЕ ХӨГЖЛИЙН ҮЕТЭЙ НЭГДЭВ

### П.Лувсандорж

Шилжиж буй, хөгжиж буй эдийн засагтай орнуудын амьдралын туршлагаас орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааныг баяжуулах ач холбогдолтой шилжилтийн болон хөгжлийн эдийн засагт өвөрмөц шинжлэх ухааны асуудлууд төрөн гарч байна. Судалгааны хүрээ тэлэгдэх хэрээр мэдлэгийн энэ сан арвижих болно.

Шийдлээ хүлээсэн шилжилт, хөгжлийн асуудлуудыг нэгэн зэрэг цогц байдлаар шийдвэрлэх боломж гарч шилжилтийн үе хөгжлийн үетэй нэгдэн нийлэв. Энэ бол хөгжиж буй эдийн засгийн хөгжлийн нэгэн зүй тогтол бололтой.

Олон улсын харьцуулсан судалгаанаас үзэхэд, Монгол Улс бол одоогийн байдлаар бага орлоготой орноос дунд орлоготой зэрэглэлд дөнгөж шилжээд байгаа хөгжиж буй орон билээ.

Төлөвлөгөөт эдийн засаг байхгүй, хөгжиж буй орнуудыг шилжилтийн эдийн засагтай гэж хэлдэг үгүй ч, үнэн хэрэгтээ, тэнд зах зээлийг чиглэсэн шилжих, хөгжих үйл явц зэрэгцэн явагдаж байгаа.

Монгол Улс социалист орон болохоор хөгжиж буй орон байж таарахгүй гэж байсан хуучин цагийн алдааг дахин давтахгүйн тулд хөгжиж буй эдийн засагтай орон болохоо хүлээн зөвшөөрч сайтар судлах учиртай. Хөгжлийн бэрхшээл, өвөрмөц асуудлууд гараад байгаагийн гол учир шалтгаан нь хөгжиж буй эдийн засагт оршино.

Хөгжлийн эдийн засагчид хөгжиж буй орнуудын эдийн засгийн нийтлэг шинжийг доорх байдлаар тодорхойлсон. Үүнд:

- амьдралын доогуур түвшинтэй (доогуур орлого, тэгш бус байдал, эрүүл мэнд, боловсролын доогуур түвшин);
- бүтээмжийн доогуур түвшинтэй;

- хүн амын хурдацтай өсөлттэй;
- ажилгүйдэл ба дутуу ажил эрхлэлтийн өсч буй болон өндөр түвшинтэй;
- ХАА-н үйлдвэрлэлээс хамаарах хамаарал хүчтэй ба анхдагч бүтээгдэхүүний экспорт хийдэг;
- гадаад орнуудаас хүчтэй хамааралтай, бас эмзэг байдалтай. Үндэсний эдийн засгийн үйл ажиллагааны хувьд:
- эдийн засгийн янз бүрийн секторуудын хоорондох интеграцчлалын зэрэг бага (интеграцлагдаагүй)

Эдийн засгийн нийлүүлэлтийн хувьд:

- Аж үйлдвэрийн секторт олигополь зах зээл ноёрхсон, бүтээгдэхүүний үнэ өндөр тогтдог.
- Түүхий эдийн үнийн өсөлт нь эцсийн бүтээгдэхүүний үнэд шууд нөлөөлдөг.
- Пүүсүүд цалингаа төлөх болон түүхий эдээ худалдан авахын тулд санхүүгийн байгууллагаас зээл авдаг. Зээлээр үйл ажиллагаагаа явуулдаг учир үйлдвэрлэлийн зардал өсдөг.
- Санхүүгийн зах зээл дээр мөнгөний бодлого хөгжингүй орнуудын нэгэн адил ажилладаггүй учир мөнгөний нийлүүлэлтийг хянах боломж муутай. Санхүүгийн дуализм (албан болон албан бус мөнгөний зах зээлүүд)-зээлийн хүүгийн бууралт нь хөрөнгө оруулалтын өсөлтийг бий болгодоггүй, харин нэг зах зээлээс нөгөө рүү мөнгөний шилжих хөдөлгөөн бий болгодог. Жишээ нь, албан ёсны зах зээлээс албан бус зах зээл рүү мөнгөн хөрөнгө шилжихийг хэлж болно.

Зах зээл дээр эрэлт ба нийлүүлэлтийн мэдрэмж бага. Өөрөөр хэлбэл, зах зээл муу ажилладаг гэсэн үг.

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн эдгээр нийтлэг шинж төрх нь үндэсний эдийн засгийн бүтэцтэй их төлөв холбоотой, түүнд газар нутаг, газар зүйн байршил ба орлогын түвшин, түүхэн ба хараат байдал, материаллаг ба хүний нөөцийн байдал, улсын ба хувийн секторын харьцаа, аж үйлдвэржилтийн бүтцийн дүр төрх, гадаад эдийн засаг ба улс төрийн хүчний хамаарал нөлөөтэй.

Монголын эдийн засагт дээрх нийтлэг шинж төрхүүд, хамаарлын шалтгаанууд бараг бүгдээрээ байгаа. Хэдэн жишээ:

- ажилгүйдлийн зэрэгцээ дутуу ажил эрхлэлт өргөн хүрээтэй;
- ХАА-н үйлдвэрлэл ДНБ-ний 35 хувийг эзэлж байгаа нь хөгжиж буй орнуудын дундаж үзүүлэлтээс дээгүүр;
- гол экспорт нь хөгжиж буй орнуудын нэгэн адил түүхий эд, тэр дундаа алт, зэс, ноос, ноолуур, малын арь шир;
- дэлхийн хөгжлийн илтгэлд (2000-Дэлхийн банк) гадаадын зээл

тусламжаас хараат байдалд орсон таван орны тоонд Монгол Улс орсон.

Энэ бүхнээс харахад шийдлээ хүлээсэн асуудал олон байна. Бас хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлого Монгол оронд хамаарагдах болж байна.

Хүснэгт 1 Эдийн засгийн цар хүрээ 2007 оны байдлаар

	Үндэсний нийт тэрбум ам.долл.	орлого эзлэх байр	Нэг хүнд ам.долл.	Оногдох ҮНОэзлэх байр	ДНБ: жилийн өсөлт
АНУ	13886.4	1	46040	16	2.0
ОХУ	1069.8	12	7530	79	8.1
БНХАУ	3126.0	4	2370	132	13.0
Монгол	3.4	156	1290	149	10.2
Болгар	35.1	73	4580	97	6.2
Вьетнам	65.4	58	770	169	8.5
Сингапур	148.4	41	32340	31	7.7
Гонконг (БНХАУ)	218.6	32	31560	33	6.4
БНСУ	955.8	14	19730	48	5.0
Япон	4828.9	2	37790	26	2.1
Дэлхий	528504	-	7995	-	3.8
Бага ба дунд орлоготой орнууд	13141.1	-	2366	-	8.1
Зүүн Ази, номхон далайн орнууд	4172.8	-	2182	-	11.4
Өндөр орлоготой орнууд	39685.9	-	37570	-	2.5

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2009

Хүснэгтийн тоонуудаас харахад нэг хүнд оногдох ҮНО-ын хэмжээ Монгол Улсад:

- Их орлоготой орнуудаас 29.1;
- Азийн бар орон, БНСУ-аас 15.3;
- дэлхийн дундажаас 6.2;
- Зүүн Ази, Номхон далайн орнуудаас 1.7;
- Бага ба дунд орлоготой орнуудаас 1,8;
- Хөрш орнууд: ОХУ-аас 5.8;
- БНХАУ-аас 1.8

дахин тус тус бага байв.Энэ бол Монгол Улсын үндэсний эдийн засгийн цар хүрээ маш жижиг, бага орлоготой орнуудын зэрэглэлд багтаж байлаа гэсэн үг.

Хүснэгт 2

ДНБ-ний салбарын бүтэц

	Хөдө аж ахуй		Аж үйлдвэр		Боловсруулах үйлдвэр		Үйлчилгээ	
	1995	2007	1995	2007	1995	2007	1995	2007
Дэлхий	4	3	30	28	20	18	65	59
Бага дунд орлоготой орнууд	14	10	34	37	22	18	52	53
Зүүн Ази, Номхон далайн орнууд	19	12	44	47	31	30	36	41
Монгол	41	23	29	41	12	4	30	36
БНХАУ	20	11	47	49	34	32	33	40
Вьетнам	27	20	29	42	15	21	44	38

Эх сурвалж Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2009

2007 оныг 1995 онтой харьцуулахад: 41 хувьтай байсан хөдөө аж ахуй 23 хувьтай, 29 хувьтай байсан аж үйлдвэр 41 хувьтай болж байраа сольсон байна. Аж үйлдвэр өндөр хувьтай байгаа ч боловсруулах аж үйлдвэр 4-хөн хувьтай байна. Олборлох аж үйлдвэртэй, түүхий эдэд түшиглэсэн эдийн засагтай гэсэн үг.

2008 оны байдлаар: нэг хүнд оногдох үндэсний нийт орлого:  
(ам.доллар)

- дэлхийн дундаж 10357;
- бага орлоготой орнуудад 1407;
- дунд орлоготой орнуудад 6154;
- бага (Lower) дунд орлоготой орнуудад 4592;
- их (Upper) дунд орлоготой орнуудад 12297;
- их орлоготой орнуудад 37141;

Монгол Улсад 3480 ам.доллар болсон байна. Энэ нь Монгол Улс бага орлоготой орнуудаас дээгүүр; дунд орлоготой орнуудаас доогуур завсрын зэрэглэлд оржээ гэсэн үг.

Олон улсын судалгаанаас үзэхэд зах зээлийн тогтолцооны хөгжил эдийн засгийн хөгжлийн түвшнээс хамаардаг. Хөгжилтэй зах зээл эдийн засгийн хөгжлийн өндөр түвшинг хангахад тусалдаг байна. Эдийн засгийн эрх чөлөө, байгалийн арвин нөөц хоёр Монгол орныг эдийн засгийн их өсөлтийн замд гаргах гэж байна.

Гадаад хүчин зүйлсээс илүүтэй гэж хөгжлийн эдийн засагчид үздэг хөгжлийн байнгын, хүчтэй нөлөө бүхий хүчин зүйл бол эдийн засгийн эрх чөлөө юм. Хувийн өмчийн аюулгүй байдал, өрсөлдөх эрх чөлөө, хувийн сонголт, сайн дунрын солилцоо зэрэг эдийн засгийн эрх чөлөөний төвшингөөр илэрхийлэгдэх эдийн засгийн эрх чөлөөний индексээр (ЭЗЭЧИ) Монгол Улс дэлхийн орнуудын 74 дүгээр байрт орсон байна. Энэ бол манай орны тухайд харьцангуй өндөр үзүүлэлт.

Монгол оронд Оюутолгой, Таван толгой, Дорнод Уран болон бусад хэд хэдэн дэлхийн хэмжээний уул уурхайн том ордууд ашиглалтанд орох гэж байна. Зэс, нүүрс эрчим хүч, газрын тос боловсруулах шинэ үйлдвэрүүд баригдах гэж байна.

Үндэсний эдийн засгийн өсөлт, бүтцийн прогнозын тооцоогоор дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 оныхтой харьцуулахад 2015 онд 2,8 дахин; 2021 онд 7,6 дахин өснө. Үүний дотор: хөдөө аж ахуйнх: 2,1 дахин; 4,4 дахин; аж үйлдвэрийнх: 3,4 дахин; 9,4 дахин; үйлчилгээ: 2,1 дахин; 6,7 дахин тус тус өснө.

Хүснэгт 3


Үндэсний эдийн засгийн өсөлт, бүтцийн прогноз

	2010	2015	2018	2021
ДНБ оны үнээр тэрбум Т	5997,0	16988,2	27754,9	45727,4
Нэг хүнд ногдох ДНБ: ам долл.	1833	4780	7318	11242
ДНБ -ний салбарын бүтэц %	100	100	100	100
Хөдөө аж ахуй	14	11	10	8
Аж үйлдвэр	46	58	56	57
Үйлчилгээ	40	31	34	35

Эх сурвалж: Н.Энхбаяр. Макро эдийн засгийн цаашдын хандлага. 2009

Үндэсний эдийн засгийн салбарын бүтцэд 2010 онд аж үйлдвэр 46 хувь эзлэж байсан бол 2015 онд 58; 2021 онд 57 хувь тус тус болж өснө; хөдөө аж ахуй 2010 онд 14 хувь байсан бол 2015 онд 11 хувь; 2021 онд 8 хувь тус тус болж буурна. Үйлчилгээний салбар 2010 онд 40 хувь байсан бол 2015 онд 31 хувь, 2021 онд 35 хувь тус тус болж буурна.

Зураг 1



**Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн** 2010 онтой харьцуулахад 2015 онд 2.1 дахин, 2021 онд 4.4 дахин өснө. Энэ бол багагүй өсөлт. Гэвч аж үйлдвэрийн түргэн өсөлтөөс хамааралтайгаар дотоодын нийт бүтээгдэхүүнд түүний эзлэх хувь 2010 онд 14 хувь байсан бол 2015 онд 11 хувь, 2021 онд 8 хувь тус тус болж буурах хандлагатай.

“Монгол мал” хөтөлбөр хэрэгжиж эхлэв. Одоо аймаг, сумын төвийг түшиглэсэн малтай, тариалантай, малчид, тариаланчдын орон сууцтай, соёл, ахуйн үйлчилгээтэй “Монгол суурин” хөтөлбөр хэрэгтэй байна.

**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн** 2010 онтой харьцуулахад 2015 онд 3.4 дахин, 2021 онд 9.4 дахин тус тус нэмэгдэнэ. Энэхүү маш том, маш хурдан өсөлтөөс шалтгаалан дотоодын нийт бүтээгдэхүүнд 2010 онд 46 хувь эзлэж байсан бол 2015 онд 58, 2021 онд 57 хувь тус тус болж нэмэгдэнэ. Энэ бол аж үйлдвэр үндэсний эдийн засагт тэргүүлэх байртай болно гэсэн үг.

**Мал аж ахуйд суурилсан аж үйлдвэр** шинэ технологитой, шинэ бүтээгдэхүүн эзэмших замаар хөгжих ирээдүйтэй. Ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөвөр; тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн монгол бренд байж чадна. Жилд дундажаар 3,2 мянган тонн ямааны ноолуур бэлтгэдэг, 3,5 мянган тонн ноолууран бүтээгдэхүүн гаргах үйлдвэрлэлийн чадалтай болсон. Гол үйлдвэрлэгчид нь “Говь” болон “Буян” компаниуд юм. Одоо бүтээгдэхүүн, түүний түүхий эдийн чанарт онцлон анхаарч өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлагатай. Монгол Улс дэлхийн ноолуурын зах зээлд Хятад Улсын дараа ордог. Ноос, арьс шир боловсруулах талаар хивс, эсгий, эсгий гутал, нэхий дээл, савхин эдлэл үйлдвэрлэж байгаа, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлж чадвал гадаад зах зээлд гарах ирээдүйтэй.

**Байгалийн нөөцөд суурилсан аж үйлдвэр** хөгжих ирээдүй их бий. Том уурхайнууд эхлээгүй байхад уул уурхайн бүтээгдэхүүн аж үйлдвэрт 70 орчим хувьтай байна. Энэ бол уул уурхайн аж үйлдвэр үндэсний нийт эдийн засагт тэргүүлэх үүрэгтэй гэсэн үг. Эндээс “Голланд өвчний” эсрэг тэмцэх том асуудал бас гарна. “Голланд өвчин” нь том ордуудыг нээснээр эдийн засагт аж үйлдвэржүүлэлт үүсч, үндэсний валютын ханш чангарч, аж үйлдвэрийн бусад салбарын бүтээгдэхүүний экспортын өрсөлдөх чадварыг худалдааны түнш орнуудынхаас харьцангуй сул болгож, улмаар импортыг нэмэгдүүлж экспортыг багасгаж үндэсний эдийн засгийг бүхэлд нь унагаж болох түүхэн сургамж бүхий аюултай үйл явц билээ. “Голланд өвчний” аюулыг багасгахын тулд:

- Үндэсний валютын ханшны чангаралтыг удаашруулах, үүний тулд их өсөлтийн үеийн орлогын хагасыг гадаадад гаргаж хадгалуулах, ирээдүйн хөгжилд зориулж аажмаар зарцуулах;
- Ядуурлыг бууруулах, арилжааны бус хүрээний цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг нарийн тооцоотой, хатуу хяналттай байлгах;
- Аж үйлдвэрийн өөр салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гадаад зах зээлд гарцтай өндөр технологийн шинэ бүтээгдэхүүн шинэ үйлдвэрлэл эзэмшихэд зориулж бүтээлч хөрөнгө оруулалт хийх нь зохистой.

Олон улсын туршлагаас үзэхэд их өсөлтийн орлогын үлэмж хэсгийг үндэсний эдийн засгийн ирээдүйтэй, тэргүүлэгч шинэ салбар, шинэ үйлдвэрлэл бий болгоход зориулдаг байна.

**Үйлчилгээний салбаруудын бүтээгдэхүүн** 2010 оныхтой харьцуулахад 2015 онд 2,1 дахин, 2021 онд 6,7 дахин өснө. Энэ бол багагүй өсөлт. Гэвч аж үйлдвэрийн түргэн өсөлттэй хамааралтайгаар дотоодын нийт бүтээгдэхүүнд түүний эзлэх хувь 2010 онд 40 хувь байсан бол 2015 онд 34, 2021 онд 35 хувь тус тус болж буурах хандлагатай.

Энэ салбарт худалдаа, тээвэр, харилцаа холбоо аялал, жуулчлалын үйлчилгээнүүдийг хамруулан авч үзлээ. Үйлчилгээний салбарын эзлэх хувь өндөр байх нь хөгжилтэй эдийн засгийн шинж байдаг. Манайд бол энэ салбар олигтой хөгжөөгүй боловч өндөр хувьтай байгаа нь цаашид засагдах тодорхой хугацааны үзүүлэлт байх магадлалтай.

Үндэсний эдийн засгийн “ялагч” гэж хөгжлийн эдийн засагт нэршсэн тэргүүлэх салбар бий болгох өвөрмөц үүргээ Монголын төр биелүүлж эхлэв. Монгол орны нөхцөлд ийм салбар нь эхлээд уул уурхай, дагалдах нь боловсруулах үйлдвэр, шийдвэрлэгч нь мэдлэгт суурилсан салбар байх бололтой.

Монгол Улсын Засгийн Газар болон “Айвенхоу Майнз Монголиа Инк” ХХК, “Айвенхоу Майнз Лимитет”, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед”-ийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ 2010 оны гуравдугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр болов. Хувь нийлүүлэгч болсон Монголын талыг Монголын төр төлөөлөх болов гэсэн үг.

Хөгжиж буй орнуудын хөгжилд хэрэглэдэг “тэгш биш” хөгжлийн стратеги Монголд хэрэгжиж эхлэв. Хувь нийлүүлэгчдийн гэрээний дагуу Засгийн газрыг “Оюутолгой” ХХК-ийн хувьцааны 34 хувийг эзэмшигч, төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” ХХК төлөөлөх болов. Энэ бол төрийн секторын толгойлогч компани. Гол ажлыг өөрөө гүйцэтгэж, дагалдах ажлуудыг хувийн секторын компаниудаар хийлгэх боломж бүрдэж байна.

Засгийн газар эхний ээлжинд шинээр баригдах боловсруулах үйлдвэрүүдийн төслөө зарлаад байна. Зарим төслийг нэрлэвэл:

- **“ОЮУ ТОЛГОЙН ТӨСӨЛ”** зэсийн баяжмалын үйлдвэр хоногт 100 мянга, жилд 35 сая тонн хүдэр боловсруулна. Цаашид өдөрт 150 мянга, жилд 56 сая тонн хүдэр боловсруулах чадалтай болно.
- **“ТАВАН ТОЛГОЙ”** төсөл жилд 20 сая тонн нүүрс олборлож, 15 сая тонн баяжуулсан нүүрс үйлдвэрлэнэ.
- **“ЗЭС ХАЙЛАХ ҮЙЛДВЭР”** төсөл жилд 70 мянган тонн катодын зэс үйлдвэрлэнэ.
- **“ХАР МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР”** жилд хоёр сая ган хайлж, төмөр замын рельс, хуудас төмөр, том оврын металл хийцүүдийг үйлдвэрлэнэ.
- **“КОКС ХИМИЙН ҮЙЛДВЭР”** төсөл коксын үйлдвэрээс ялгарах шатдаг хий, битум, бусад химийн түүхий эдийг боловсруулна.
- **“ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”** дотоодын түүхий эдэд тулгуурласан, технологи нь олон улсын стандартад нийцсэн байна.
- **“НҮҮРС ХИМИЙН ҮЙЛДВЭР”** төсөл нүүрсний орд дээр химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолбор байгуулна.  
Энэ бүхэн бол түүхий эдэд түшиглэсэн эдийн засгаас боловсруулах үйлдвэрлэлд түшиглэсэн эдийн засагт шилжих анхны алхамууд болно. Боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх дараагийн алхамууд хийгдэх арвин их нөөц Монголд бий.



- Монгол Улс нүүрсний 162.3 тэрбум тонн нөөцтэй. Ойролцоогоор 200 гаруй орд илрүүлээд байгаа юм. Үүнээс өнөөдрийн байдлаар 50 гаруй ордыг ямар нэг хэмжээгээр ашиглаж байна.
- Монгол орны Ураны батлагдсан нөөц одоогийн байдлаар дэлхийн жилийн хэрэгцээнээс давах 80-аад мян.тонн; таамаг нөөц сая гаруй тонн. Тэгэхлээр, их нөөцтэй гэсэн үг.
- Монгол, улс нефтийн бүтээгдэхүүний хувьд 100 хувь гадаадаас хамааралтай, 2010 оны байдлаар газрын тосны бүтээгдэхүүний 98.2 хувийг ОХУ-аас, нэг хувийг БНХАУ-аас 0.6 хувийг БНСУ-аас тус тус импортолсон байна. Одоогийн байдлаар Тамсагийн сав газраас 200 сая тонн, Зүүн Баянгийн сав газраас 173 сая баррель түүхий тосны нөөц илрээд байгаа. Энэ нь хэрэгцээгээ хангахуйц түүхий тосны нөөцтэй гэсэн үг.

Бүтээн байгуулалтын их ажлыг дагаж уул уурхай, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн төрийн өмчит шинэ компаниуд төрөн гарах болно. Эдийн засагт төрөөс үзүүлэх нөлөөг аль болох хязгаарлах зорилготой **тэнцвэрт бус өсөлтийн стратеги** байдаг. Түүний гол санаа нь хөгжлийн үйл явцыг аливаа зүйлийн илүүдэл, дутагдал зэрэг олон тэнцвэрт бус хүчин зүйлийн нөлөөгөөр хөгжүүлэх, ялангуяа, хувийн аж ахуйтнуудын сонирхлыг төрүүлэхэд оршдог. Одоогоор тодроод байгаа уул уурхайн том ордууд, түлш, эрчим хүчний том эх үүсвэрүүдийн төслүүдийн толгойлох үйлдвэрлэлийг төр хариуцаж, дагалдахуудыг хувийн сектороор хийлгэх том бодлого хэрэгтэй байна.

Хөгжиж буй эдийн засагт төрийн оролцоо харьцангуй их байдаг тухай хөгжлийн эдийн засгийн онол Монголын туршлагаар дахин нотлогдож байна.

Монголын эдийн засагт бараг 100 хувьтай байсан төрийн сектор шилжилтийн үйл явцад 30 хүрэхгүй хувьтай болоод байгаа, удахгүй том ордуудыг ашиглаад ирэхээр 50 гаруй хувьтай болж магад. Энэ бол айх хэрэггүй, хөгжлийн явцад гарах гайхалтай өөрчлөлт. Хөгжиж буй эдийн засагт төрийн секторын үүрэг асар их. Үүнийг НҮБ хүлээн зөвшөөрч бидний боловсруулсан саналын дагуу тогтоол гаргаж байсан үе бий. Үүнийг сурах бичгүүдэд байдаг хөгжилтэй зах зээлд төрийн үүрэг бага гэдэг ойлголттой хольж хутгаж болохгүй, социализм руу буцаж байна гэж айх хэрэггүй. Монголын төр татвар төлөгчдийн мөнгө, хувьчлалын орлого, гадаадын зээл тусламжийн хөрөнгө бүгдийг зохицуулж, заримыг эзэмшиж байгаа. Нэг үгээр, Монголын төр бол Монголын хамгийн том хөрөнгөтөн. Тодорхой жишээ: Монголын төр аж ахуйн нэгжүүдийн цэвэр орлогын 40 гаруй хувийг төсөвдөө цуглуулж ДНБ-ний 20 гаруй хувийг хэрэглэж байгаа. Энэ хоёр баримт бол дээр дурдсан онолын дүгнэлтүүдийн тоон нотолгоо.

Хувийн сектор хэдийгээр тооны хувьд их жинтэй болсон ч пүүс компаниуд нь эдийн засгийн цар хүрээгээр бага, өрсөлдөх чадвараар сул дорой байгаа. Үүний учир нь тэдгээр пүүс, компаниуд хөгжлийн явцад биш, шилжилтийн нөлөөгөөр хөгжиж буй эдийн засгийн орчинд бий болсонд оршино. Тэд хөгжлийн явцдаа хүчтэй болох нь мэдээж.

Хувийн секторын хөгжилд төрийн хүчтэй дэмжлэг хэрэгтэйг Монголын туршлага нотлон харуулж байна. Энэ бол хөгжиж буй эдийн засгийн хөгжлийн нэгэн зүй тогтол бололтой. Энэ зүй тогтлыг амьдралд хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл нь төрийн болон хувийн секторууд хоорондын хамтын ажиллагаа, хамтарсан хэлбэр байх болно.

Төрийн болон хувийн секторууд хоорондын түншлэлийг шинэ дээд шатанд гаргах хэрэгцээ байна. Шаардлагатай үед төр хувийн компаниудад санхүүгийн дэмжлэг, татаас олгодог, хэрэгцээтэй гэж үзвэл төрийн өмчийн шинэ хувьчлал явуулж болдог эдийн засаг, эрх зүйн орчин хэрэг болно.

Ийнхүү, Монгол Улс эхлээд уул уурхайн үйлдвэрийг, дагуулаад боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийн шинэ бүтэц үүсгэх том зорилтыг ирэх 10 жилд дэвшүүлж байна. Зорилтоо биелүүлсэн тухайд, Монгол Улс бага дунд орлоготой орноос их дунд орлоготой орны зэрэглэлд дөхөж очих; түүхий эдэд суурилсан эдийн засгаас боловсруулах үйлдвэрт суурилсан эдийн засагт шилжих үйлст том алхам хийх болно.

**Мэдлэгт суурилсан эдийн засгийн** тухайд гэвэл, хамгийн энгийн утгаар, санхүүгийн, техник, технологийн болон бусад мэдлэг, инженерийн ур чадварыг ашиглан үйлчилгээ, бүтээгдэхүүн бий болгож түүнийгээ экспортлох явдал юм. Үүний тулд өндөр мэдлэгтэй, инженерийн ур чадвартай хүний нөөц, сургууль, үйлдвэр хэрэгтэй. Монгол Улс оюутны хотхон, технологийн паркаас эхлээд Финлянд Улс шиг төрийн-оюутны--компанийн түншлэлийн хөндлөн тогтолцоо бүрдүүлэх хэрэгтэй. Тэгсэн цагт Майкрософт компанид зөвлөмж өгөх монгол оюутан төрөх болно. Түүний хамт уул уурхайн салбар өөрөө “мэдлэгийн” компаниуд төрүүлэх юм байна. Монголд амжилттай хөгжсөн хөрөнгийн бирж Хойт Америкийн Торонтогийн болон Африк тивийн Йоханнесбургийн биржүүд шиг Ази тивийн уул уурхайн санхүүжилтийн төв болох магадлалтай гэнэ. Түүний хүрээнд хөрөнгө оруулалтын банк, брокерийн компани, хөрөнгө удирдлагын компани, санхүүгийн зөвлөх болон бусад мэрэгшлийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд төрөн гарах боломжтой гэнэ. Төрийнхөө дэмжлэгтэйгээр харьцангуй богино хугацаанд мэдлэгт суурилсан эдийн засагтай болсон БНСУ, Сингапур, Хонконгийн туршлагаас суралцах, хамтран ажиллах нь чухал.

**Ном зүй.**

1. Н.Энхбаяр.”Макро эдийн засгийн цаашдын хандлага УБ.2009 он
2. Монгол Улсын статистикийн эмхэтгэл УБ.2009 он